

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН ТАЙЛАН

Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгтгэсэн
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар A/06

Эрдэнэт

┌
Аудитын тайлан баталгаажуулах тухай
└

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүргийн”-ийн 1.1, 1.3, 2.4, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайлан /ОРА-2023/01/НА-СТА-ТЕЗ/-г баталгаажуулсугай.

2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд орсон “Төсвийн захирагчид, орон нутгийн өмчит газрууд”-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн хэлбэрийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, зөрчлийн албан шаардлагын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, аймгийн хэмжээнд нэгтгэн, үр дүнгийн талаар 2023 оны 11 сарын 30-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Батжаргал/, аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Ш.Ганболд нарт зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хүргүүлж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Буян-Ундрах/, ахлах аудитор /В.Жавзмаа, Г.Оргилмөрөн/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/6 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Аудитын дүгнэлтийн жагсаалт

№	Байгууллагын нэр	Аудитын код	Дүгнэлт
1	Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ОРА-2023/103/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
2	Эрдэнэт сан	ОРА-2023/100/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
3	Орхон аймгийн засаг даргын тамгын газар	ОРА-2023/104/НА-СТА-ТШЗ	хязгаарлалттай
4	Аймгийн Засаг даргын төсөл хөтөлбөр	ОРА-2023/93/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
5	Эрдэнэт хотын захирагчийн алба	ОРА-2023/105/НА-СТА-ТШЗ	хязгаарлалттай
6	Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	ОРА-2023/73/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
7	Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ОРА-2023/110/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
8	Орхон аймгийн Сум дундын ойн анги	ОРА-2023/113/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
9	"Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа" УТҮГ	ОРА-2023/05/НА-СТА-ОНА	еөрчлөлтгүй
10	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	ОРА-2023/03/НА-СТА-ОНА	еөрчлөлтгүй
11	Амралт аялал жуулчлалын Их шүтээн цогцолбор	ОРА-2023/01/НА-СТА-ОНА	сөрөг
12	"Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ	ОРА-2023/02/НА-СТА-ОНА	еөрчлөлтгүй
13	Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК	ОРА-2023/06/НА-СТА-ОНА	еөрчлөлтгүй
14	Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газар	ОРА-2023/81/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
15	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар	ОРА-2023/109/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
16	Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар	ОРА-2023/111/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
17	Орхон аймгийн Хот тохижуулах газар	ОРА-2023/106/НА-СТА-ТШЗ	хязгаарлалттай
18	Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	ОРА-2023/89/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
19	Орхон аймгийн Хот байгуулалт барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ	ОРА-2023/04/НА-СТА-ОНА	еөрчлөлтгүй
20	Орхон аймгийн орон нутгийн өмчийн газар	ОРА-2023/107/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
21	Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	ОРА-2023/112/НА-СТА-ТШЗ	хязгаарлалттай
22	Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний алба	ОРА-2023/108/НА-СТА-ТШЗ	еөрчлөлтгүй
23	Орхон аймгийн Жаргалант сумын Засаг дарга	ОРА-2023//НА-СТА-ТТЗ	еөрчлөлтгүй

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүдэх аудиторын 2023 оны 04
дүгээр сарын 25-ны өдрийн А/6 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

Төлбөрийн актын жагсаалт

6117143690
0440073 9042806

№	Байгууллагын нэр	Аудитын код	Төлбөрийн актын дугаар	Дүн /төгрөг/
1	Орхон аймгийн Анхны оч ӨЭМТ	ОРА-2023/121/НА-СТА-ТШЗ	04/04	90,000
2	Орхон аймгийн Энхжих Мандирваа ӨЭМТ	ОРА-2023/115/НА-СТА-ТШЗ	18/18	69,000
3	Орхон аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төв	ОРА-2023/80/НА-СТА-ТШЗ	21/21	355,553
4	Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	ОРА-2023/73/НА-СТА-ТШЗ	22/22	126,000
5	Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	ОРА-2023/73/НА-СТА-ТШЗ	23/23	122,015
6	Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын	ОРА-2023/81/НА-СТА-ТШЗ	34/34	760,917
7	Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын	ОРА-2023/81/НА-СТА-ТШЗ	35/35	1,123,130
8	Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар	ОРА-2023/89/НА-СТА-ТШЗ	38/38	193,700
9	Эрдэнэт хотын Захирагчийн алба	ОРА-2023/105/НА-СТА-ТШЗ	43/43	469,000
10	Эрдэнэт хотын Захирагчийн алба	ОРА-2023/105/НА-СТА-ТШЗ	44/44	458,665
11	Эрдэнэт хотын Захирагчийн алба	ОРА-2023/105/НА-СТА-ТШЗ	45/45	489,763
12	Орхон аймгийн Жаргалант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	ОРА-2023/112/НА-СТА-ТШЗ	57/57	258,000
13	Орхон аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн	ОРА-2023/97/НА-СТА-ТШЗ	69/69	592,000
14	Мөнхийн гэгээ ӨЭМТ	ОРА-2023/118/НА-СТА-ТШЗ	79/79	280,466
15	Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ОРА-2023/110/НА-СТА-ТШЗ	83/83	1,200,000
16	Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ОРА-2023/110/НА-СТА-ТШЗ	84/84	133,492
17	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сан	ОРА-2023/101/НА-СТА-ТШЗ	85/85	26,800
18	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сан	ОРА-2023/101/НА-СТА-ТШЗ	86/86	477,254
19	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар	ОРА-2023/109/НА-СТА-ТШЗ	90/90	1,242,649
20	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар	ОРА-2023/109/НА-СТА-ТШЗ	91/91	1,474,032
21	Мэнд цэцэн Өрхийн эрүүл мэндийн төв	ОРА-2023/122/НА-СТА-ТШЗ	108/108	124,000
22	Мэнд цэцэн Өрхийн эрүүл мэндийн төв	ОРА-2023/122/НА-СТА-ТШЗ	109/109	89,950
23	Орхон аймгийн Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан	ОРА-2023/102/НА-СТА-ТШЗ	110/110	15,683,500
24	Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар	ОРА-2023/111/НА-СТА-ТШЗ	113/113	1,778,306
25	Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар	ОРА-2023/111/НА-СТА-ТШЗ	114/114	455,244

26	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	ОРА-2023/06/НА-СТА-ОНА	115/115	2,417,861
27	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	ОРА-2023/06/НА-СТА-ОНА	116/116	56,443
28	Учралт баяр Өрхийн эрүүл мэндийн төв ХХН	ОРА-2023/119/НА-СТА-ТШЗ	117/117	861,000
29	Учралт баяр Өрхийн эрүүл мэндийн төв ХХН	ОРА-2023/119/НА-СТА-ТШЗ	118/118	1,594,010
30	Учралт баяр Өрхийн эрүүл мэндийн төв ХХН	ОРА-2023/119/НА-СТА-ТШЗ	119/119	5,000,000
31	Учралт баяр Өрхийн эрүүл мэндийн төв ХХН	ОРА-2023/119/НА-СТА-ТШЗ	120/120	500,000
32	Учралт баяр Өрхийн эрүүл мэндийн төв ХХН	ОРА-2023/119/НА-СТА-ТШЗ	121/121	235,500
33	Үйлс бадрах өрхийн эрүүл мэндийн төв ХХН	ОРА-2023/116/НА-СТА-ТШЗ	122/122	850,000
34	Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	ОРА-2023/117/НА-СТА-ТШЗ	123/123	200,000
35	Эрдэнэт цэцэрлэг хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа	ОРА-2023/05/НА-СТА-ОНА	124/124	76,960
36	Орхон аймгийн Хот тохижуулах газар	ОРА-2023/106/НА-СТА-ТШЗ	125/125	1,002,820
37	Орхон аймгийн Хот тохижуулах газар	ОРА-2023/106/НА-СТА-ТШЗ	126/126	9,271,700
38	Орхон аймгийн Хот тохижуулах газар	ОРА-2023/106/НА-СТА-ТШЗ	127/127	900,000
39	Эрдэнэт Шинжлэх ухааны технологийн парк ОНӨААТҮГ	ОРА-2023/03/НА-СТА-ОНА	128/128	6,490,000
40	Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба	ОРА-2023/04/НА-СТА-ТШЗ	129/129	945,331
41	Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба	ОРА-2023/04/НА-СТА-ТШЗ	130/130	1,278,500
42	Эрдэнэт цэцэрлэг хүрээлэн ашиглалтын өмнөх захиргаа	ОРА-2023/05/НА-СТА-ОНА	131/131	1,450,000
43	Орхон аймгийн Засаг даргын төсөл хөтөлбөр	ОРА-2023/93/НА-СТА-ТШЗ	133/133	8,224,846
44	Орхон аймгийн Засаг даргын төсөл хөтөлбөр	ОРА-2023/93/НА-СТА-ТШЗ	134/134	5,000,000
45	Орхон аймгийн Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ	ОРА-2023/01/НА-СТА-ОНА	135/135	93,895
46	Орхон аймгийн Мөнхсүндэрл ӨЭМТ ЗГБХН	ОРА-2023/120/НА-СТА-ТШЗ	136/136	493,485

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 04
дүгээр сарын 25-ны өдрийн А/06 дугаар
тушаалын 3 дугаар хавсралт

Албан шаардлагын жагсаалт

6117143690
ΦAA0073 9042906

№	Байгууллагын нэр	Аудитын код	Төлбөрийн актын дугаар	Дүн /төгрөг/
1	Орхон аймгийн Сум дундын ойн анги	ОРА-2023/113/НА-СТА-ТШЗ	18/18	148,000
2	Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	ОРА-2023/81/НА-СТА-ТШЗ	26/26	97,600
3	Эрдэнэт хотын Захирагчийн алба	ОРА-2023/105/НА-СТА-ТШЗ	31/31	5,569,988
4	Орхон аймгийн Жаргалант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	ОРА-2023/112/НА-СТА-ТШЗ	35/35	22,075,000
5	Орхон аймгийн Жаргалант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	ОРА-2023/112/НА-СТА-ТШЗ	36/36	13,053,900
6	Мөнхийн гэгээ Өрхийн эрүүл мэндийн төвт	ОРА-2023/118/НА-СТА-ТШЗ	58/58	3,491,000
7	Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ОРА-2023/110/НА-СТА-ТШЗ	63/63	108,973
8	Орхон аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	ОРА-2023/97/НА-СТА-ТШЗ	79/79	900,000
9	Орхон аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	ОРА-2023/97/НА-СТА-ТШЗ	80/80	10,000,000
10	Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар	ОРА-2023/111/НА-СТА-ТШЗ	99/99	-
11	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	ОРА-2023/06/НА-СТА-ОНА	100/100	10,189,546
12	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	ОРА-2023/06/НА-СТА-ОНА	101/101	3,000,000
13	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	ОРА-2023/06/НА-СТА-ОНА	102/102	37,082,909
14	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	ОРА-2023/06/НА-СТА-ОНА	103/103	9,000,000
15	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	ОРА-2023/06/НА-СТА-ОНА	104/104	6,400,000
16	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	ОРА-2023/06/НА-СТА-ОНА	105/105	118,944,287
17	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	ОРА-2023/06/НА-СТА-ОНА	106/106	136,300,000
18	Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ОРА-2023/103/НА-СТА-ТШЗ	107/107	29,400,000
19	Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ОРА-2023/103/НА-СТА-ТШЗ	108/108	334,656
20	Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	ОРА-2023/117/НА-СТА-ТШЗ	109/109	2,054,131
21	Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	ОРА-2023/117/НА-СТА-ТШЗ	110/110	6,205,110
22	Орхон аймгийн Хот тохижуулах газар	ОРА-2023/106/НА-СТА-ТШЗ	111/111	996,100,000
23	Орхон аймгийн Хот тохижуулах газар	ОРА-2023/106/НА-СТА-ТШЗ	112/112	17,902,100
24	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	ОРА-2023/03/НА-СТА-ОНА	113/113	20,000,000
25	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	ОРА-2023/03/НА-СТА-ОНА	114/114	10,000,000

26	Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба	ОРА-2023/04/НА-СТА-ТШЗ	115/115	-
27	Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	ОРА-2023/89/НА-СТА-ТШЗ	116/116	5,785,000
28	Орхон аймгийн Засаг даргын төсөл хөтөлбөр	ОРА-2023/93/НА-СТА-ТШЗ	120/120	182,880,120
29	Орхон аймгийн Засаг даргын тамгын газар	ОРА-2023/104/НА-СТА-ТШЗ	121/121	352,221,900
30	Орхон аймгийн Засаг даргын тамгын газар	ОРА-2023/104/НА-СТА-ТШЗ	122/122	-
31	Орхон аймгийн Засаг даргын тамгын газар	ОРА-2023/104/НА-СТА-ТШЗ	123/123	7,641,200
32	Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ	ОРА-2023/01/НА-СТА-ОНА	124/124	-
33	Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ	ОРА-2023/01/НА-СТА-ОНА	125/125	65,081,038
34	Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ	ОРА-2023/01/НА-СТА-ОНА	126/126	-
35	Орхон аймгийн Мөнхсүндрэл ӨЭМТ	ОРА-2023/120/НА-СТА-ТШЗ	127/127	6,653,329
36	Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч	ОРА-2023/01/НА-СТА-ТЭЗ	128/128	2,498,016,500

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
БҮЛЭГ 1. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
1.1. Төсвийн орлогын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарах шаардлагатай байна.	5
1.2 Төсөв хөрөнгийг зарцуулахдаа холбогдох хууль, дүрэм журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй алдаа зөрчлүүд буурахгүй давтан гарсаар байна.....	7
1.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 9,707.0 сая төгрөгийн 85 зөрчил илэрсэн бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангуулахад анхаарахаар байна.	9
БҮЛЭГ 2. ТАТВАРЫН ЗАРЛАГА	9
2.1 Татвар төлөгчдөд 3,802.0 сая төгрөгийн татварын буцаан олголтыг олгосон байна...9	9
БҮЛЭГ 3. ХУДАЛДАН АВСАН БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ	10
3.1 Аймгийн 2022 оны худалдан авах ажиллагаанаас 3,366.1 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.....	10
БҮЛЭГ 4. ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮН	11
4.1 Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанар болон тоон хэмжээний үзүүлэлт, зарцуулах төсвийг баталж, үр дүнг зарцуулсан зардлын гүйцэтгэлтэй харьцуулсан боловч дүн шинжилгээ хийгээгүй байна.....	11
БҮЛЭГ 5. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	12
5.1 Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	12
БҮЛЭГ 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ	13
6.1 Орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.	13
БҮЛЭГ 7: ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	14
АУДИТЫН ДҮГНЭЛТ:.....	14
ЗӨВЛӨМЖ:.....	14
ХАВСРАЛТ.....	15

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орхон аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогыг шилжүүлэг, улсын төсөөт төвлөрүүлэх орлого	6
Хүснэгт 2	Орхон аймгийн төсвийн орлогын төлөвлөлт	6
Хүснэгт 3	Орон нутгийн төсвийн татварын орлогын биелэлт	6
Хүснэгт 4	Орон нутгийн төсвийн татварын бус орлогын биелэлт	7
Хүснэгт 5	Орон нутгийн төсвийн зардал, тодотгол	9
Хүснэгт 6	Орон нутгийн төсвийн зардлын гүйцэтгэл	9
Хүснэгт 7	Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтээр илэрсэн алдаа, зөрчил, шийдвэрлэлт	10
Хүснэгт 8	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл	11
Хүснэгт 9	Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт	11
Хүснэгт 10	Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
Хүснэгт 11	Нэмэлт санхүүжилтийн орлогын судалгаа	13
Хүснэгт 12	Нэмэлт санхүүжилтийн зардлын гүйцэтгэл	14

<p>Аудит үндэслэл, эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн 2022 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл • Татварын зарлага • 2022 оны худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл • Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүн • Нэмэлт төсвийн гүйцэтгэл • Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны мэдээлэл
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Сангийн яамнаас Орхон аймгийн 2022 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянасан дүн, тооцоолол, аймгийн Татварын хэлтсийн дүн, мэдээ зэрэг баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.</p> <p>Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.</p> <p>Аудитад дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын үндсэн хууль, • Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,

<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<ul style="list-style-type: none"> • Төсвийн тухай хууль , • Төрийн аудитын тухай хууль, • Монгол улсын 2022 оны төсвийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Татварын багц хуулиуд, • Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолууд, • Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 тушаалаар баталсан “Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмж батлах тухай” • Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт <p>Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.</p>
<p>Аудит учирсан бэрхшээл</p>	<p>хийхэд хүндрэл</p> <p>Аймгийн Татварын хэлтэс нь холбогдох тооцоо судалгааг иж бүрэн ирүүлээгүй нь аудит хийх цаг хугацаанд нөлөөлсөн.</p>

БҮЛЭГ 1. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

1.1. Төсвийн орлогын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлд 2022 оны төсвийн жилд Орхон аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 91,010.6 сая төгрөгөөр, 16 дугаар зүйлд орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 9,915.5 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, улсын төсөвт төвлөрүүлэх орлого өссөн байна.

Хүснэгт №1 Орхон аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, улсын төсөвт төвлөрүүлэх орлого

/сая төгрөгөөр/				
№	Орлогын эх үүсвэр	2021 он	2022 он	Зөрүү
1	Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг	5,353.7	9,915.5	4,561.8
2	Төвлөрүүлэх орлого	24,601.6	91,010.6	66,409.0

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 06/04 дүгээр тогтоолоор 2022 оны төсвийн нийт орлогын эх үүсвэрийг 161,382.4 сая төгрөгөөр баталсныг 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 10/02 дугаар тогтоолоор 160,380.4 сая төгрөг буюу 1,002.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Хүснэгт №2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт

/сая төгрөгөөр/				
№	Орлогын эх үүсвэр	Анх баталсан	Тодотгосон	Зөрүү
1	Татварын орлого	159,920.0	158,918.0	(1,002.0)
2	Татварын бус орлого	1,462.4	1,462.4	-
3	Тусламжийн орлого	10,733.8	9,915.5	(818.3)
4	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	84,023.9	91,010.6	6,986.7

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн татварын бус орлогод өөрчлөлт ороогүй бөгөөд татварын болон тусламжийн орлогыг бууруулж тодотгосон нь Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж тодотгосонтой холбоотой байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 06/04 дүгээр тогтоолоор орон нутгийн 2022 оны төсвийн орлогын нийт дүн, төсвийн зардлыг 181,563.8 сая төгрөгөөр баталсан ба 2022 оны 07 дугаар сарын 07-ны 10/02 дугаар тогтоолоор 189,188.1 сая болгож тодотгосон байна.

Аймгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр авч үзвэл 19 нэр төрлийн татварын орлого 110 хувь буюу 15,672.3 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Хүснэгт №3 Орон нутгийн төсвийн татварын орлогын биелэлт

/сая төгрөгөөр/					
Орлогын нэр төрөл	2021 оны гүйцэтгэл	2022 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	37,949.8	45,201.9	50,601.8	5,399.8	112
Үйл ажиллагааны орлого	280.0	406.5	428.1	21.6	105
Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	3,230.8	3,130.0	2,487.1	(642.9)	79

Хөрөнгө борлуулсны орлого	2,344.9	1,212.3	2,449.4	1,237.0	202
Шууд бус орлого	858.4	1,501.5	933.7	(567.7)	62
ХХОАТ-ын буцаалт	(2,410.8)	(3,802.0)	(3,802.0)	-	100
Үл хөдлөх хөрөнгийн татвар	11,902.0	19,014.3	22,455.3	3,440.9	118
Бууны татвар	37.2	40.8	57.2	16.4	140
АТБӨЯХАТатвар	1,074.8	1100.0	1,182.8	82.7	108
Малд ногдуулах албан татвар	24.9	32.0	33.7	1.7	105
Улсын тэмдэгтийн хураамж	386.6	463.5	501.1	37.6	108
ТТАМ-ын орлогын албан татвар	40.9	40.0	67.5	27.5	169
Хог хаягдлын хураамж	666.3	1,301.5	1,612.3	310.8	124
Бусад татвар	2,014.5	-	496.5	496.5	
Газрын төлбөр	19,083.0	21,027.5	23,107.5	696.6	103.8
Газрын дуудлага худалдаа	400.8		108.5	108.5	
Ойн нөөц ашигласны	27.3	19.5	20.1	0.6	103
Ус рашааны нөөц ашигласны	352.6	351.2	328.7	(22.5)	94
Нийт дүн	78,263.9	159,271.0	174,943.4	15,672.3	110

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Орон нутгийн төсөвт төвлөрөх 2022 оны татварын орлогыг 159,271.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 174,943.4 сая төгрөг төвлөрч 15,672.3 сая төгрөг буюу 10 хувиар давж биелсэн байна. Татварын орлогыг биелэлтээр авч үзвэл дараах шалтгаантай байна.

- **Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварын** орлогыг 45,201.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 50,601.8 сая төгрөг төвлөрч 5,399.8 сая төгрөг буюу 12 хувиар давсан нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажиллагсдын цалин болон төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн доод хэмжээг Засгийн газраас шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.
- **Хөрөнгө борлуулсны орлого** 1,212.3 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 2,449.3 сая төгрөг төвлөрч, 1,237.0 сая төгрөг буюу 102 хувиар давж биелсэн буюу өмнөх оны гүйцэтгэлээс 104.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- **ААН-ийн орлогын албан татварыг** 68,230.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 71,873.7 сая төгрөг төвлөрч 3,643.7 сая төгрөг буюу 5 хувиар давж биелсэн.
- **Үл хөдлөх хөрөнгийн татварыг** 19,014.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 22,455.3 сая төгрөг төвлөрч, 3,440.9 сая төгрөгөөр буюу 18 хувиар давж биелсэн нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой байна.
- **Хөрөнгийн орлогын татварыг** 3,130.0 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 2,487.1 сая төгрөг төвлөрч, 642.9 сая төгрөгөөр буюу 21 хувиар дутуу төвлөрсөн нь хадгаламжийн эзэмшигчийн тоо, хадгаламжийн мөнгөн дүн буурсантай холбоотой байна.
- Шууд бус орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс өндөр төлөвлөсөн бөгөөд 567.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Аймгийн татварын бус орлогын төлөвлөгөө 97 хувь буюу 644.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №4 Орон нутгийн төсвийн татварын бус орлогын биелэлт

/сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	2021 оны гүйцэтгэл	2022 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Торгуулийн орлого	1,755.2	1,430.0	1,689.9	259.9	118
Бусад орлого	171.5		280.1	281.1	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	1,936.8	8,504.5	7,399.3	(1,083.7)	64.1

Туслах үйл ажиллагааны орлогоос	16.4	26.6	16.4	(10.2)	61.7
ОНХС-ийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	5,353.7	9,915.5	9,836.2	(79.2)	99
Тусламж, санхүүжилтийн орлого	47,337.7	19,850.0	19,205.7	(644.3)	97
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30.0	29.9	30.0	0.1	100.3
Нийт дүн	51,247.60	19,879.9	19,235.7	(644.4)	97

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

- Хүү, торгуулийн орлогыг 1,430.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,689.2 сая төгрөг төвлөрч 259.9 сая төгрөгөөр давж биелсэн.
- Үндсэн үйл ажиллагааны орлогыг 8,504.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 7,399.3 сая төгрөг төвлөрч 1,105.2 сая төгрөгөөр тасарсан нь Эрдэнэт санд орох Эрдэнэт үйлдвэртэй хамтын ажиллагааны санхүүжилт орж ирээгүй, реклам сурталчилгааны самбарын болон бусад үйл ажиллагааны орлого дутуу төвлөрснөөс шалтгаалсан байна. Багуудын байр шинээр баригдаж, ашиглалтад хүлээн авсантай холбоотойгоор тус байруудын ашиглаагүй хэсгийг түрээсэлж, түрээсийн орлого нэмэгдэх боломжтой байгааг судалж шийдвэрлэн, тогтмол зардлыг санхүүжүүлэх талаар судалгаа хийх шаардлагатай байна.
- Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 26.6 сая төгрөгөөс гүйцэтгэлээр 16.4 сая төгрөг төвлөрч 10.2 сая төгрөг тасарсан нь цар тахалтай холбоотой сургуулиудын цайны газрын түрээсийн орлого бүрэн төвлөрөөгүйтэй холбоотой байна.

Сангийн сайдын 2022 оны А7 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөв хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын дагуу орон нутагт хуваарилсан 40 хувийг бодитой тооцоолсон эсэхийг аудитад хамруулахаар аймгийн Татварын хэлтэст хандсан боловч аудитын дүн, дүгнэлтэд шаардлагатай мэдээллийг ирүүлээгүй болно. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Энэ хуулийн 6.4-т зааснаас бусад тохиолдолд төрийн аудитын байгууллага аудит хийхдээ зөвхөн Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний эрх олгосон төрийн аудитын байгууллагын албан хаагч төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл, баримт бичиг, түүнчлэн шалгагдагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл, баримт бичгийн зөвхөн тухайн харилцаатай холбогдох хэсэгтэй хуульд заасан журмын дагуу танилцах, хэвлэх, олшруулж авах эрхтэй, 15.4-т “Энэ хуулийн 15.2-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулах, аудитад шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг нуун дарагдуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байх тул Монгол Улсын Засгийн газрын нэгдсэн тайланд тусгуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

Цаашид төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч, орлогыг бодитой төлөвлөх, аймгийн Татварын хэлтсийг үр нөлөөтэй ажиллуулах шаардлагатай байна.

1.2 Төсөв хөрөнгийг зарцуулахдаа холбогдох хууль, дүрэм журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй алдаа зөрчлүүд буурахгүй давтан гарсаар байна.

Сангийн яамнаас ирүүлсэн орон нутгийн 2022 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжийн дагуу аймгийн 2022 оны төсвийн суурь зарлагыг нийт 40,267.2 сая төгрөгөөр төсөл боловсруулж Төсвийн тухай хуулийн 8.4.3 дахь заалтын дагуу Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Сангийн яам 10,681.8 сая төгрөгөөр буюу 26.5 хувиар бууруулан 29,585.4 сая төгрөгөөр хянажээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 06/04 дүгээр тогтоолоор орон нутгийн 2022 оны төсвийн зардлыг 97,540.0 сая төгрөгөөр баталсан ба 2022 оны 07 дугаар сарын 07-ны 10/02 дугаар тогтоолоор 637.6 сая төгрөгөөр нэмж, тодотгосон байна.

Хүснэгт №5 Орон нутгийн төсвийн зардал, тодотгол

				/сая төгрөгөөр/	
№	Зарцуулах эрх, эх үүсвэр	Анх баталсан	Тодотгосон	Зөрүү	
1	Орон нутгийн төсвийн байгууллага	12,866.2	13,913.2	1,047.0	
2	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	5,123.9	5,123.9	-	
3	Хөрөнгө оруулалт	62,126.3	67,698.0	5,571.7	
4	Орон нутгийн хөгжлийн сан /сумдын/	5,392.8	4,983.6	(409.2)	
5	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээний ашиглалтын зардал	12,030.8	6,458.9	(5,571.9)	
	ДҮН	97,540.0	98,177.6	637.6	

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Төсөв тодотгохдоо тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин зарим зардлууд улсын төсвөөс санхүүжих болсонтой холбогдуулан хөрөнгө оруулалтын зардал болон орон нутгийн төсөвт 6 байгууллагын төсөвт нэмж тодотгожээ.

Аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг 206,263.8 сая төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 184,587.7 сая төгрөг буюу 89.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн нэгтгэсэн төсвийн зарлагын дүнд урсгал зардал 71.4 хувь, хөрөнгийн зардал 28.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт №6 Орон нутгийн төсвийн зардлын гүйцэтгэл

							/сая төгрөгөөр/	
№	Үзүүлэлт	2021 он		2022 он		Хувь		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл			
1	Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл	46,577.7	46,082.5	11,653.4	10,699.7	91.8		
2	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,776.7	2,593.8	3,954.8	3,429.2	86.7		
3	Хангамж, бараа материалын зардал	1,844.3	1,814.1	1,960.2	1,940.6	99.0		
4	Нормативт зардал	914.8	896.7	129.9	119.0	91.6		
5	Эд хогшил, урсгал засварын зардал	753.9	748.0	1,292.7	1,287.8	99.6		
6	Томилолт, зочны зардал	174.3	143.0	67.2	62.6	93.0		
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,524.5	14,880.0	29,123.5	18,454.9	63.3		
8	Бараа үйлчилгээний бусад зардал	3,915.2	3,819.7	1,722.4	1,640.0	95.2		
9	Татаас, урсгал шилжүүлэг	27,809.2	27,585.5	93,793.0	93,698.7	99.9		
10	Хөрөнгийн зардал	35,809.3	30,114.7	62,008.5	52,871.9	85.3		
11	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	578.8	401.6	558.2	383.1	68.6		
	Нийт дүн	145,678.7	129,079.6	206,263.8	184,587.7	89.5		

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг хэтрүүлээгүй бөгөөд хэмнэлт үүсгэж ажилласан хэдий ч тайлант оны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар төсөв хөрөнгийг зарцуулахдаа холбогдох хууль, дүрэм журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй алдаа зөрчлүүд давтан гарсаар байна.

1.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 9,707.0 сая төгрөгийн 85 зөрчил илэрсэн бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангуулахад анхаарахаар байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан заавар, аргачлалын дагуу төсөв захирагчдын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, холбогдох хэлтсээс хуулийг хэрэгжүүлж ажиллахыг цахимаар болон танхимын 3 удаагийн сургалтаар мэдээлэл хийж, чиглэл өгсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөх чиг үүрэг бүхий албан тушаалтны талаарх мэдээлэлд 4, тээврийн хэрэгсэл хэсэгт холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн судалгаанд 24, тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн ангилал зэрэглэлд хамаарах албан тушаалтны ажлын байрны нөхцөлд 3 байгууллагыг хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит нийт 133 байгууллагаас 63 байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 9,707.0 сая төгрөгийн 85 зөрчил илэрсэн.

Хүснэгт №7 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтээр илэрсэн алдаа, зөрчил, шийдвэрлэлт

Хуулийн заалт	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/сая төгрөгөөр/ Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
6.1	1	0.1	2	12.8			3	12.9
6.4					3	130.2	3	130.2
8.1	2	0.9	1	0.2	1	0.6	4	1.7
9.2			1	8.0			1	8.0
9.3	1	1.7					1	1.7
12.1.1.	35	9.5	3	4.2	3	1.8	41	15.5
14.4.4.			2	19.3	1		3	19.3
15.1.3.	2	1.6	1	4.0	1	2.8	4	8.4
15.1.4.			2	11.0			2	11.0
15.1.5.	2	0.6	1	1.0			3	1.6
15.1.6.			3	71.0	2	26.2	5	97.2
15.1.7.	1	0.1					1	0.1
15.2.3.	1	4.0	5	35.3			6	39.3
15.2.4.			7	6,857.7	1	4.4	7	6,862.1
15.2.6.			1	2,498.0			1	2,498.0
НИЙТ ДҮН	45	18.5	27	9,522.5	12	166.0	85	9,707.0

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангуулахад анхаарах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ТАТВАРЫН ЗАРЛАГА

2.1 Татвар төлөгчдөд 3,802.0 сая төгрөгийн татварын буцаан олголтыг олгосон байна.

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12, шинэчилсэн найруулсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 19 дүгээр тушаалаар баталсан “Илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгах журам”-ын 2.7 дах хэсэгт заасны дагуу татвар төлөгчдөд 3,802.0 сая төгрөгийн татварын буцаан олголтыг олгосон байна.

БҮЛЭГ 3. ХУДАЛДАН АВСАН БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

3.1 Аймгийн 2022 оны худалдан авах ажиллагаанаас 3,366.1 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хөрөнгийн зардалд худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3-д заасны дагуу тайлагнасан байна.

Хүснэгт №8 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Тайлант онд санхүүжих дүн	/сая төгрөгөөр/	
				Гэрээний дүн	Хэмнэлт + Хэтрэлт -
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	156	36,476.4	31,816.3	34,882.0	1,594.4
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	1	750.0	684.8	750.0	-
Байгаль хамгаалах сан	16	795.8	782.2	795.8	-
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	18	33,944.8	16,300.0	32,365.5	1,579.3
Аймгийн авто замын сан	3	528.5	528.5	519.0	9.5
Эрдэнэт сан	2	738.4	738.4	731.0	7.4
Сумдын орон нутгийн хөгжлийн сан	79	6,910.9	4,994.9	6,735.4	175.5
Нийт дүн	275	80,144.8	55,845.1	76,778.7	3,366.1

Эх сурвалж: Орхон аймгийн 2022 оны худалдан авах ажиллагааны тайлан

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 06/04 дүгээр тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтыг 62,126.3 сая төгрөгөөр баталсныг 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 10/02 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж 67,698.0 сая төгрөг болгон 5,571.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт №9 Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Аймгийн ИТХ-ын 2021.12.02 №06/04	Аймгийн ИТХ-ын 2022.07.07 №10/02	/сая төгрөгөөр/
				Зөрүү /өсөлт + бууралт-/
1	Шилжих хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	14,590.6	19,519.2	4,928.6
2	Шинэ хөрөнгө оруулалт	35,508.8	36,276.9	768.3
3	Төсөл, хөтөлбөр	12,026.9	11,901.9	(125.0)
	Нийт дүн	62,126.3	67,698.0	5,571.7

Эх сурвалж: Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн нийт хөрөнгө оруулалтын 11,901.9 сая төгрөг буюу 17.6 хувийг төсөл арга хэмжээнд, 19,519.2 сая төгрөг буюу 28.8 хувийг шилжих хөрөнгө оруулалтад, 36,276.9 сая төгрөг буюу 53.6 хувийг шинээр эхлэх хөрөнгө оруулалтад зарцуулахаар баталсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих төсөл, арга хэмжээг 3 удаа тодотгож баталжээ. Орон нутгийн хөрөнгө

оруулалтаар 2022 онд хэрэгжих төсөл, арга хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 11/03 дугаар тогтоолоор 76,252.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 59,713.6 сая төгрөгийн санхүүжүүлэх дүнтэй 385 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 259 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, 251 худалдан авах ажиллагаа амжилттай болж, 6 гэрээ байгуулаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн 40,781.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгож, захиалагчийн болон зохиогчийн хяналтын 1,582.2 сая төгрөгийг хяналтын болон барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн, орон нутгийн ерөнхий орлогын дансанд 8,136.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Орхон аймагт нийт 83,188.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 21,353.6 сая төгрөгийн санхүүжүүлэх дүнтэй 28 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталжээ. Үүнээс аймагт эрх шилжсэн 55,625.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээ, эрх шилжээгүй 62,304.4 сая төгрөгийн 23 төсөл, арга хэмжээ байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн 18 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, гэрээ байгуулсан ба 14 төсөл, арга хэмжээнд 12,959.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 106.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

БҮЛЭГ 4. ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮН

4.1 Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанар болон тоон хэмжээний үзүүлэлт, зарцуулах төсвийг баталж, үр дүнг зарцуулсан зардлын гүйцэтгэлтэй харьцуулсан боловч дүн шинжилгээ хийгээгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт хамрагдах 22 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанар болон тоон хэмжээний үзүүлэлт, зарцуулах төсвийг баталж, үр дүнг зарцуулсан зардлын гүйцэтгэлтэй харьцуулж ирүүлсэн хэдий ч дүн шинжилгээ хийгээгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 184,587.7 сая төгрөг буюу 89.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 12,364.5 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 9,136.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2,641,866.0	2,575,990.5	65,875.5	97.5%
2	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	126,154,392.2	115,156,815.2	10,997,577.0	91.3%
3	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	294,747.6	236,496.9	58,250.7	80.2%
4	70927 Төрийн нийтлэг бусад үйлчилгээ	654,194.8	568,161.5	86,033.3	86.8%
5	70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	229,824.2	215,972.3	13,851.9	94.0%
6	70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	61,039,538.5	51,909,549.8	9,129,988.7	85.0%
7	70805 Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого	38,068.0	38,068.0		100%
8	71101 Авто зам	1,128,500.0	1,116,389.1	12,110.9	98.9%

/сая төгрөгөөр/

9	71302 Мэдээллийн нэгдсэн тогтолцоо, дэд бүтэц	133,598.4	133,466.5	131.9	99.9%
10	71403 Ойжуулалт	226,403.4	210,000.1	16,403.3	92.8%
11	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	242,836.7	241,428.2	1,408.5	99.4%
12	71502 Хот байгуулалт, тохижилт	5,661,838.7	5,605,635.0	56,203.7	99.0%
13	71509 Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого удирдлага	236,267.8	235,676.3	591.5	99.7%
14	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	37,621.7	31,568.4	6,053.3	83.9%
15	71701 Биеийн тамир спорт	86,973.4	67,941.4	19,032.0	78.1%
16	71702 Соёл урлаг	402,956.9	268,009.7	134,947.2	66.5%
17	71801 Сургуулийн өмнөх боловсрол	2,762,474.4	2,371,434.8	391,039.6	85.8%
18	71802 Ерөнхий боловсрол	2,871,982.9	2,591,860.1	280,122.8	90.2%
19	71804 Мэргэжлийн боловсрол	673,478.4	452,573.2	220,905.2	67.0%
20	Насан туршийн болон албан бус боловсрол	50,117.0	45,348.7	4,768.3	90.5%
21	71902 Нийгмийн халамж	137,980.0	132,184.0	5,796.0	95.8%
22	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	558,182.8	383,100.0	175,082.8	68.6%
	ДҮН	206,263,843.8	184,587,669.7	21,676,174.1	89.5%

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, арга, хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл өмнөх оноос 0.9 хувиар өссөн байна.

Аймгийн Засаг дарга Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилтийг 2022 онд 88.4 хувьтай биелүүлж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс батламж болон Засгийн газрын зарим чиг үүргийн орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийг нэгтгэж, хяналт шинжилгээ үнэлгээ хийн, баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлжээ.

БҮЛЭГ 5. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг нэр төрлөөр бүртгэж, зардлын зүйл тус бүрээр эрх нээн зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн харьяа төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд 7,520.3 сая төгрөгийн орлого төвлөрч, 5,556.5 сая төгрөгийг зарцуулан, 1,389.6 сая төгрөгийг Хөгжлийн банканд, орон нутгийн төсөвт 584.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт № 11 Нэмэлт санхүүжилтийн орлогын судалгаа

№	Эх үүсвэрийн төрөл	2021 он	2022 он	/сая төгрөгөөр/
				Өсөлт + /бууралт-
1	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгийн эх үүсвэр	2,413.2	3,628.5	1,215.3
2	Дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан эх үүсвэр	888.1	2,127.2	1,239.1
3	Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,378.4	1,764.6	(613.8)
4	Хандив тусламжийн орлого	260.5		(260.5)

	Нийт дүн	5,940.2	7,520.3	1,580.1
--	----------	---------	---------	---------

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Нийт зарцуулалтын 99.0 хувь буюу 7,452.5 сая төгрөгийг урсгал зардалд, 1.0 буюу 78.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Хүснэгт № 12 Нэмэлт санхүүжилтийн зардлын гүйцэтгэл

№	Зардлын төрөл	2021 он	2022 он	/сая төгрөгөөр/
				Өсөлт + /бууралт-
1	Цалин хөлс, НДШ-ийн зардал	570.2	392.5	(177.7)
2	Байр ашиглалтын зардал	310.8	154.3	(156.5)
3	Хангамж, бараа материалын зардал	417.7	384.7	(33.0)
4	Норматив зардал	62.5	72.9	10.4
5	Урсгал засвар, эд хогшлын зардал	379.1	248.2	(130.9)
6	Томилолтын зардал	4.5	11.3	6.8
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамж	1,480.4	3,718.7	2,238.3
8	Бараа үйлчилгээний бусад зардал	1,997.3	2,074.1	76.8
9	Тэтгэмж урамшууллын зардал	243.4	395.8	152.4
10	Хөрөнгийн зардал	194.7	78.0	(116.7)
	Нийт дүн	5,660.6	7,530.5	1,869.9

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Нэмэлт санхүүжилтийн дансны тайлангийн нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад 1,869.9 сая төгрөгөөр өссөн ба Хөгжлийн банканд төвлөрүүлсэн түрээсийн орон сууцны эргэн төлөлтөөс шалтгаалжээ.

БҮЛЭГ 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ

6.1 Орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Засгийн газрын гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн улсын төсөвт эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлэх гэрээ буюу МОН-2301 төслийн 7,446.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг орон нутагт олгох аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувиас Сангийн яам суутган тооцож, хаасан байна.

Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд “Эрдэнэт хотын хатуу хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл” 8.1 сая еврогийн санхүүжилт хийгдэж, төсөл хэрэгжиж дуусаагүй, ажлын гүйцэтгэл гараагүй тул төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд бүртгээгүй, Сангийн яамны нэгтгэсэн тайланд бүртгэлтэй байна.

Бүгд Найрамдах Франц Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл” төслийн ажил бүрэн дуусаагүй, улсын комисс хүлээн аваагүй, туршилт тохируулгын ажил хийгдээгүй, эзэмшигчийн асуудал шийдвэрлээгүй тул төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгээгүй байна. Харин 2022 онд орон нутагт олгох аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувиас 13,621.4 сая төгрөгийг суутган тооцсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-д “тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих”

гэж заасны дагуу зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 7: ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны аудитаар 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, алдаа давтан гараагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Төсвийн орлогын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарах шаардлагатай байна.
- Төсөв хөрөнгийг зарцуулахдаа холбогдох хууль, дүрэм журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй алдаа зөрчлүүд буурахгүй давтан гарсаар байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 9,707.0 сая төгрөгийн 85 зөрчил илэрсэн бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангуулахад анхаарахаар байна.
- Татвар төлөгчдөд 3,802.0 сая төгрөгийн татварын буцаан олголтыг олгосон байна.
- Аймгийн 2022 оны худалдан авах ажиллагаанаас 3,366.1 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.
- Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанар болон тоон хэмжээний үзүүлэлт, зарцуулах төсвийг баталж, үр дүнг зарцуулсан зардлын гүйцэтгэлтэй харьцуулж ирүүлсэн хэдий ч дүн шинжилгээ хийгээгүй байна.
- Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Өмнөх оны аудитаар 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, алдаа давтан гараагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

- Аймгийн төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч, орлогыг бодитой төлөвлөх, аймгийн Татварын хэлтсийг үр нөлөөтэй ажиллуулах;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоох, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгч, үр дүн, гүйцэтгэлийг хэлэлцэж байх;
- Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх.

ХАВСРАЛТ

Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206,263,843.8	184,587,669.8
УРСГАЛ ЗАРДАЛ	143,697,200.5	131,332,686.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,904,219.7	37,633,929.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,269,863.5	9,486,954.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,383,555.3	1,212,712.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,954,810.9	3,429,258.9
Хангамж, бараа материалын зардал	1,960,178.7	1,940,611.8
Нормативт зардал	129,977.5	119,033.6
Эд хогшил, урсгал засварын зардал	1,292,686.9	1,287,829.4
Томилолт, зочны зардал	67,245.1	62,576.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,123,457.0	18,454,967.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,722,444.8	1,639,985.2
ТАТААС	1,200,000.0	1,182,752.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,200,000.0	1,182,752.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,592,980.8	92,516,004.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	91,808,947.2	91,803,424.5
Бусад урсгал шилжүүлэг	784,033.6	712,579.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	62,008,460.5	52,871,883.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	558,182.8	383,100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	206,263,843.8	185,426,779.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,915,501.9	9,836,251.3
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	160,701,022.5	168,191,157.1
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,647,319.4	7,399,370.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	4,576,906.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	5,415,818.6

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,530,586.4
УРСГАЛ ЗАРДАЛ	7,452,574.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,082,723.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351,619.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,859.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,345.5
Хангамж, бараа материалын зардал	384,737.6
Нормативт зардал	72,943.8
Эд хогшил, урсгал засварын зардал	248,156.2
Томилолт, зочны зардал	11,298.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,718,743.5
Бараа үйлчилгээний бусад зардал	100,019.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,369,851.0
Бусад урсгал шилжүүлэг	395,782.4
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,974,068.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	78,011.8
Дотоод эх үүсвэрээр	78,011.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,520,306.9
Нэмэлт санхүүжилтийн орлого	7,520,306.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	168,191,157.1
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	- 10,279.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,279.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	